



Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 491.4 тэрбум төгрөгт болж, 487.0 (99.1%) тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 4.4 (0.9%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.



Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3.1 (0.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 1.7 (27.4%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч дотоодын барилгын байгууллагынх 4.8 (1.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар /тэрбум төгрөг/





Дотоодын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 400.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 76.8 (16.1%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 76.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 72.9 (22.2 дахин) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 9.9 тэрбум төгрөгт хүрч 8.7 (8.8 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.



Энэ оны эхний улирлын байдлаар барилга угсралт, их засварын ажлын 28.6 хувийг орон сууцны барилга, 48.9 хувийг орон сууцны бус барилга, 20.6 хувийг инженерийн барилга, байгууламж, 1.9 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс их засварын ажлын эзлэх хувь 1.1 пунктээр, инженерийн барилга, байгууламжийнх 14.4 пунктээр тус тус өссөн бол орон сууцны барилгын эзлэх хувь 2.2 пунктээр, орон сууцны бус барилгынх 13.3 пунктээр буурсан байна.




Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр /тэрбум төгрөг/






Орон сууцны бус барилга, төрлөөр жил бүрийн эхний улирлын байдлаар /тэрбум төгрөг/



Орон сууцны бус барилгын гүйцэтгэл 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 240.5 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 63.2 (20.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд үйлдвэрийн барилгын гүйцэтгэл 34.1 (25.6%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч худалдаа, үйлчилгээний барилгынх 4.5 (36.6%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 2.9 (32.1%) тэрбум төгрөгөөр, сургууль, соёлын барилгынх 16.7 (31.2%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 73.2 (76.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил /тэрбум төгрөг/



Улаанбаатар хотод 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 187.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 38.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 5.1 пунктээр буурсан байна. Харин барилга угсралт, их засварын ажлын 61.5 хувийг аймаг, орон нутагт баригдаж буй барилга угсралт, их засварын ажил эзэлж байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 172.7 тэрбум төгрөг, Дорноговь аймагт 79.0 тэрбум төгрөг болсон бөгөөд тус аймгуудын нутаг дэвсгэрт төмөр замын барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.